

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ

БАТЛАВ

Я.САРАНСҮХ



ГАЗРЫН ТОСНЫ САЛБАРТ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭГЭЭР ~~ХАЙГУУЛЫН~~ ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЯВУУЛСАН ГЭРЭЭЛЭГЧИЙН НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ӨРТӨГ
НӨХӨГДСӨН БОЛОН НӨХӨГДӨХ ЗАРДЛЫН ХЭМЖЭЭ, ГАЗРЫН ТОСНЫ ЭКСПОРТ,
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТООЦОО, ХУВААРИЛАЛТАД БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙХ
АУДИТАД ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖЛИЙН**
ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2023 оны 02 дугаар сарын
02-ны өдөр

Дугаар *УАТ-АХ/*
2023-07

Улаанбаатар
хот

Ажлын зорилго: Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажилд аудитын багт байгаль орчны чиглэлийн нарийн мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлж, хамтран ажиллана.

Ажил гүйцэтгэх хугацаа: 2023.4.01-2023.6.01

Байршил: Үндэсний аудитын газар

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3, 17 дугаар зүйлийн 17.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд, Газрын тосны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2-т заасны дагуу Газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2021 онд хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аудит хийж баталгаажуулна.

ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ

Байгаль орчны мэргэжлийн зөвлөх шинжээч нь аудитын багтай хамтран Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг журам, АДБОУС болон холбогдох бусад баримт бичигт нийцүүлэн чанартай, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй хэлбэрээр цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх үүрэгтэй.

Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Ашигт малтмал, газрын тосны газар болон Монголын алт ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК, Петровис ресурс ХХК, Метангаз ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК-ийн үйл ажиллагааг хамруулан ажиллаж, компанийн холбогдох үйл ажиллагааны баримт материалтай танилцана. Бэлтгэсэн ажлын баримт материалд тулгуурлан аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатанд дараах ажил үүргийг хийж гүйцэтгэн, тайлан ирүүлнэ. Үүнд:

1. Гэрээлэгчийн 2021 онд төлөвлөсөн байгаль орчны нөхөн сэргээх ажил нь холбогдох хууль тогтоомжийн дагуу бодитой боловсруулж, хянаж, баталсан эсэхэд нотлох баримттай, үндэслэл бүхий дүгнэлт гаргах;
2. Хөрсний дээж авалт, лабораторийн шинжилгээ, биологийн нөхөн сэргээлт, хайгуулын талбай буцаалтын байгаль орчны нөхөн сэргээх ажлыг холбогдох хууль

тогтоомж, стандартын дагуу хийсэн эсэхэд нотлох баримттай, үндэслэл бүхий дүгнэлт гаргах;

3. Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан зардал бодитой, үнэн зөв эсэхийг холбогдох тайлан, баримт, үйлдвэрлэлийн бааз болон газар дээр нь очиж, тулган баталгаажуулж, дүгнэлт гаргах;

ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Аудитын хүрээнд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж буй болон Монголын алт ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК, Петровис ресурс ХХК, Метангаз ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК-ийн хайгуулын үйл ажиллагаа явуулсан гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын холбогдох тайлан, мэдээнд байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой ажлын гүйцэтгэлийг хамруулна.

ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН, БҮТЭЭГДЭХҮҮН

Зөвлөхийн ажлын гүйцэтгэлээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

Аудитын үе шат	Гүйцэтгэл	Хүлээгдэж буй үр дүн
Гүйцэтгэлийн үе шат	1. Гэрээлэгчийн байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулсан өртөг нөхөх зардлын задаргааг он тус бүрээр ангилна.	Гэрээлэгчийн Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгасан ажлын бодит гүйцэтгэлийг тулган баталгаажуулж, ажлын тайлан ирсэн байна.
	2. Өрмийн хаягдал шингэнийг саармагжуулах, технологийн хаягдал буюу тостой бохир шороог цэвэршүүлэх, хатуу хог хаягдлын цэгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн шингэн хаягдлын сангийн нөхөн сэргээлт хийсэн эсэхэд дүгнэлт гаргана.	
	3. Байгаль орчны үнэлгээний ажил болон байгаль орчны хяналт шинжилгээ хийсэн эсэх, хөрсний дээж авалт, авсан дээжийн лабораторийн шинжилгээ, биологийн нөхөн сэргээх ажлыг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу хийсэн эсэхэд дүгнэлт гаргана.	
	4. Гэрээлэгчийн байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээх төлөвлөгөөнд тусгагдсан ажлын бодит гүйцэтгэлийг тулган баталгаажуулсан ажлын тайланг бичгээр ирүүлнэ.	
Тайлагналын үе шат	1. Аудитын тайлангийн төсөл боловсруулахад оролцох, асуудлын шинжилгээний бүлгийн дагуу бичсэн дэд тайлангууд болон нэгдсэн тайланд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө. /Шалгагдагч байгууллагын санал мөн хамаарна/	Дэд болон нэгтгэсэн тайлангийн төсөл боловсруулсан байна.
	2. Тайланг Аудитын зөвлөл, УИХ-ын Төсвийн байнгын хороогоор хэлэлцэхэд аудитын багт зөвлөмж өгч оролцох.	Аудитын тайлан баталгаажсан байна.

ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, аудитын гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатанд оролцох Зөвлөх /иргэн, хуулийн этгээд, баг байж болно/ нь Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан болон Монголын алт ХХК, Петроматад ХХК, Жи Өү Эйч ХХК, Петровис ресурс ХХК, Метангаз ресурс ХХК, Тэлмэн ресурс ХХК-ийн хөрөнгө оруулалт, өртөг нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад баталгаажуулалт хийх аудитыг гүйцэтгэхэд Үндэсний аудитын газрын аудитын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Ажлын даалгаврыг гүйцэтгэхээр шалгарсан байгаль орчны мэргэжлийн зөвлөх шинжээч нь ажил эхлүүлэх болон хүндрэл бэрхшээл, эрсдэлээс урьдчилан сэргийлэн

захиалагч /Үндэсний аудитын газар/-тай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх явцад шийдвэрлэх боломжгүй асуудал үүссэн тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд даруй мэдэгдэнэ.

ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА

Зөвлөх шинжээч нь байгаль орчны чиглэлээр ажлын дадлага, туршлагатай, дүгнэлт гаргах, зөвлөх үйлчилгээний чиглэлээр ажиллаж байсан, тухайн аудитад зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн байна.

Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хувь хүн байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй хамтран ажиллана.

Тавигдах шаардлага болон ажлын туршлагын хүрээнд зөвлөхөд дараах боловсролын тусгайлсан зэрэг, үндсэн мэргэжил, мэргэшлийн шаардлага тавигдана. Үүнд:

Хуулийн этгээдийн хувьд:

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг; Хуулийн этгээдийн багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- Байгаль орчны чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байх;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийж байсан туршлагатай;
- Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;
- Төрийн болон албаны нууц, байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалах;
- Мэргэжлээрээ зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай;
- Газрын тосны чиглэлээр ажиллаж байсан бол давуу тал болно;
- Тухайн мэргэжлийн чиглэлээр 5-оос доошгүй жил ажилласан байх;

Ажиллах хүчний шаардлага:

- Байгаль орчны чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж байсан туршлагатай;
- Мэргэжлийн англи хэл эсхүл хятад хэлний мэдлэгтэй;
- Компьютерын өргөн хэрэглээний программууд дээр ажиллах чадвартай;
- Багаар ажиллах, ачаалал даах чадвартай;
- Газрын тосны чиглэлээр ажиллаж байсан бол давуу тал болно;
- Төрийн албан хэрэг хөтлөлт, архивын талаар мэдлэгтэй, сургалтад хамрагдсан бол давуу тал болно.

Баг, хувь хүний хувьд:

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, бусад үнэмлэх, сертификатын хуулбар;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг;
- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх);
- Газрын тосны чиглэлээр ажиллаж байсан бол давуу тал болно;
- Англи болон хятад хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.

Дээрх ажлын даалгаврын 6-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн баталгаажсан хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд


гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Байгаль орчны мэргэжлийн зөвлөх шинжээчийн ажлын хөлсийг харилцан тохиролцож, төлбөрийн нөхцөлийг ажлын гүйцэтгэлд үндэслэн гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.

Хянасан:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР

 Д.ОТГОНБАЯР

Боловсруулсан:


АХЛАХ АУДИТОР


 Д.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТОР

 Л.НЯМТӨМӨР

 Ц.БАТСҮХ

 Ц.ЦЭРЭННАМЖИЛ

 Ж.МӨНХТУУЛ